



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/229

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Мөрөн суманд ашиглагдаж байгаа хяналтын камерын кабелийн худаг, сувагчлал, агаарын баганын түрээсийн 2021 оны 06 дугаар сар хүртэлх төлбөрт 2,649,174 (Хоёр сая зургаан зуун дөчин есөн мянга нэг зуун далан дөрвөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,649,174 (Хоёр сая зургаан зуун дөчин есөн мянга нэг зуун далан дөрвөн мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд батлагдсан "Гудамжны хяналтын камерын кабелийн худаг, сувагчлал, агаарын баганын түрээс, цахилгааны төлбөрийн зардал"-аас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН

